



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 543

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймагт барьж, ашиглалтад оруулсан нийт 3,253,500,000.00 (гурван тэрбум хоёр зуун тавин гурван сая таван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан конторын барилгыг Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.
2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтүлга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах
 - 2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусгах;
 - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 03. ны өдрийн
543 дугаар тогтоолын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо жэмжээ	Нийт балансын үнэ/төгрөг/
1	Конторын барилга	2019.12.27	1	3,253,500,000